

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 12 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар А.187/244/261

Улаанбаатар  
хот

“Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах  
бодлого” батлах тухай


Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн дүрмийн 2.1.2, тус зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн VIII хуралдааны шийдвэр, Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн дэргэдэх Мобайл банкны ажлын хэсгийн 2012 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн V хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2. “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг холбогдох байгууллага, нийт оролцогчдод хүргүүлж, олон нийтэд мэдээлэхийг Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн дэргэдэх Мобайл банкны ажлын хэсгийн ахлагч (Ж.Цогтсанаа)-д даалгасугай.

3. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газрын дарга (Н.Оюунчимэг), Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын албаны дарга (У.Тамир) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга (Х.Бум-Эрдэнэ), Харилцаа холбооны зохицуулах хорооны Зах зээл, үнэ тарифын албаны дарга (Б.Мөнхбат) нарт тус тус даалгасугай.





## ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ, ЦАХИМ МӨНГӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

### НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг дэмжих, технологийн дэвшлийг ашиглаж төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх, улмаар банкны болон банкны бус санхүүгийн үйлчилгээг хүн амын орлогын түвшин, газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран найдвартай, түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх зорилготой юм.
- 1.2. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого нь тухайн систем дэх Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны оролцоо, тэдгээрийн баримтлах зарчмыг тодорхойлно.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 2.1. “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ” гэж мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, бусад цахим төхөөрөмж) ашиглаж, банкин дээр очилгүйгээр өөрийн данс руу хандаж, төлбөр гүйцэтгэх, банкны бусад үйлчилгээг авах боломжийг харилцагчид олгож байгаа банкны үйлчилгээг;
- 2.2. “Цахим мөнгө” гэж мэдээлэл технологи, харилцаа холбооны төхөөрөмжид мөнгөн хөрөнгийг урьдчилан байршуулснаар банкны данс ашиглалгүй төлбөр гүйцэтгэх боломжтой төлбөрийн хэрэгслийг;

Цахим мөнгө нь дараах шинжийг агуулна:

1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс бусад (гуравдагч) этгээд төлбөрт хүлээн зөвшөөрсөн байх;
  2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийн цахим хэлбэр бөгөөд төгрөгтэй адил үнэ цэнэтэй байх;
  3. Цахим мөнгө нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн нэрлэсэн үнээр буюу 1:1 харьцаагаар илэрхийлэгдэнэ;
  4. Цахим мөнгө нь бэлэн мөнгөнд, бэлэн мөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөнө;
  5. Цахим мөнгийг хадгаламж гэж үзэхгүй, түүнд хүү, урамшуулал бодохгүй бөгөөд хадгаламжийн даатгалд хамаарахгүй;
  6. Цахим мөнгө нь үйлчилгээ эрхлэгчээс үл хамааран төлбөрт чөлөөтэй хэрэглэгдэх эсвэл харилцан хөрвөх боломжтой байна.
- 
- 2.2. **“Цахим мөнгөний үйлчилгээ”** гэж бэлэн мөнгийг цахим хэлбэрт, цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх, цахим мөнгөний шилжүүлэг хийх, төлбөр гүйцэтгэх ажиллагааг;
  - 2.3. **“Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч”** гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк, банк бус санхүүгийн байгууллагыг;
  - 2.4. **“Тэрээт төлөөлөгч”** гэж хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хөдөлгөөнт банкны ба цахим мөнгөний үйлчилгээг гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийг;
  - 2.5. **“Тэрээт хамтрагч”** гэж хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хөдөлгөөнт банкны ба цахим мөнгөний үйлчилгээ ашиглан өөрийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг борлуулж буй иргэн, хуулийн этгээдийг;
  - 2.6. **“Цахим мөнгө хэрэглэгч”** гэж цахим мөнгөний үйлчилгээ авахаар гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

- 2.7. **“Төлбөрийн системийн оператор”** гэж Монголбанкны зөвшөөрөлтэйгээр системийн оролцогч хоорондын гүйлгээг дамжуулах, үр дүнгийн тооцоог<sup>1</sup> хийх, төлбөрийн системтэй холбоотой бусад үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг;
- 2.8. **“Санхүүгийн дундын сүлжээ”** гэж төлбөрийн системийн оролцогч хооронд төлбөрийн цахим мэдээг дамжуулах, үр дүнгийн тооцоог хийхэд төлбөрийн системийн операторын ашиглаж буй дэд бүтцийг.

## **ГУРАВ. ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 3.1. Хөдөлгөөнт банкны үйлчилгээнд төлбөр нь хийгдсэн даруйд хүчин төгөлдөр болох бөгөөд бодит цагийн зарчмыг баримтална.
- 3.2. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ эрхлэгч нь харилцагчийн сонгосон үйлчилгээний төрөл болон нөхцөлөөс хамааран мэдээллийн хамгаалалт, баталгаажуулалтын түвшинг ялгаатай тогтоож, цахим гарын үсэг, хувийн нууц дугаар, нэг удаа хэрэглэх түлхүүр үгийн төхөөрөмж гэх мэт баталгаажуулалтын хэрэгсэл ашиглаж болно.
- 3.3. Гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагч нь хөдөлгөөнт банкны үйлчилгээнд Монголбанкнаас тавигдах үндсэн шаардлагыг хангасан байна.
- 3.4. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ эрхлэгч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны төхөөрөмжийн төрөл, загвараас үл хамааран харилцагчид үйлчилгээг эрх тэгш, ижил нөхцөлтэйгөөр үзүүлнэ.

## **ДӨРӨВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 4.1. Цахим мөнгөний үйлчилгээ нь өөрийн гэсэн оноосон нэртэй байж болно.

---

<sup>1</sup> төлбөрийн системээр дамжуулан илгээсэн, хүлээн авсан гүйлгээний дүнгийн зөрүүг тооцож, үр дүнг төлбөрийн системийн оролцогчийн Төв банк (Монголбанк) дахь дансанд тусгах ажиллагаа

- 4.2. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь гэрээт төлөөлөгчөөр дамжуулан цахим мөнгөний үйлчилгээг эрхэлж болох бөгөөд гэрээт төлөөлөгчийн үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг хариуцна.
- 4.3. Гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагч нь цахим мөнгөний үйлчилгээнд тавигдах үндсэн шаардлагыг хангасан байна.
- 4.4. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны төхөөрөмжийн төрөл, загвараас үл хамааран хэрэглэгчид цахим мөнгөний үйлчилгээг эрх тэгш, ижил нөхцөлтэйгөөр үзүүлнэ.

#### **ТАВ. ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ОРОЛЦОО**

- 5.1. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу банк нь Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгөөр хөдөлгөөнт банк, цахим мөнгөний үйлчилгээг эрхэлнэ.
- 5.2. Монголбанк нь цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг энэхүү баримт бичгийн 7.2-т заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүгнэлтийг үндэслэн банкинд олгоно.
- 5.3. Монголбанк цахим мөнгөний нийт хэмжээнд хяналт тавина.
- 5.4. Банк бус санхүүгийн байгууллага цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах тохиолдолд Монголбанк нь төлбөрийн системийн харилцан зохицолдоог хадгалах зорилгоор холбогдох дүгнэлтийг гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 5.5. Монголбанк нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээн дэх банкны үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг боловсруулж, хяналт тавина.

- 5.6. Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороотой хамтран цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг гүйцэтгэж болно.
- 5.7. Монголбанк нь хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн техник, програм хангамжийн шалгуур үзүүлэлтийг тогтооно.
- 5.8. Монголбанк нь банкны цахим мөнгөнд хөрвүүлж болох төгрөгийн дээд хэмжээ, хэрэглэгчийн цахим төхөөрөмжид байрлах цахим мөнгөний дээд хэмжээ, цахим мөнгөөр хийх гүйлгээний хэмжээг журмаар зохицуулж болно.
- 5.9. Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ ашиглан хийсэн банк хоорондын төлбөр, үр дүнгийн тооцоог төлбөрийн системийн оператораар дамжуулан гүйцэтгэнэ. Үр дүнгийн тооцоог Монголбанкин дахь харилцах дансанд тусгана.
- 5.10. Монголбанк нь олон улсын стандартад нийцсэн, төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангасан хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор оролцогч талуудтай хамтран ажиллана.

## **ЗУРГАА. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ОРОЛЦОО**

- 6.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6, 7-д заасны дагуу банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр цахим мөнгөний үйлчилгээ эрхэлнэ.
- 6.2. Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагад цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг энэхүү баримт бичгийн 5.4-т заасан Монголбанкны, 7.2-т заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн олгоно.

- 6.3. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, шаардлагыг Санхүүгийн зохицуулах хороо тогтоож, хяналт тавина.
- 6.4. Санхүүгийн зохицуулах хороо нь Монголбанктай хамтран цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг гүйцэтгэж болно.
- 6.5. Санхүүгийн зохицуулах хороо нь цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллагын цахим мөнгөнд хөрвүүлж болох төгрөгийн дээд хэмжээ, цахим мөнгөөр хийх гүйлгээний хэмжээ, цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагын хэм хэмжээг журмаар зохицуулна.
- 6.6. Санхүүгийн зохицуулах хороо нь олон улсын стандартад нийцсэн, төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангасан цахим мөнгөний үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор оролцогч талуудтай хамтран ажиллана.

## **ДОЛОО. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ОРОЛЦОО**

- 7.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээнд ашиглах харилцаа холбооны техник, технологи, үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг тогтооно.
- 7.2. Харилцаа холбооны зохицуулах хороо нь цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан байгууллагын харилцаа холбооны техник, технологи, үйлчилгээний шалгуур үзүүлэлтийн дүгнэлтийг гаргаж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 7.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон улсын стандартад нийцсэн, төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангасан хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор оролцогч талуудтай хамтран ажиллана.

## НАЙМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 8.1. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээг хөгжүүлэх, эрсдэлээс сэргийлэх хүрээнд хамтран ажиллана.
- 8.2. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо болон бусад оролцогч талууд нь хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээний хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллана.
- 8.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо болон бусад оролцогч талууд нь Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээнд эрсдэлд суурилсан хяналт тавина.
- 8.4. Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээний найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах зорилгоор төлбөрийн системд оролцогч талууд үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх, хянах, удирдах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 8.5. Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээний найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор энэхүү баримт бичгийн 5.2, 6.2-т заасан зөвшөөрлийг авсан этгээд нь тасралтгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, нөөц төвийг ажиллуулна.
- 8.6. Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээнд Монголбанкнаас баримтлах төлбөр тооцооны системийн бодлогод заасан зээлийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл, хууль, эрх зүйн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, системийн эрсдэлээс гадна дараах эрсдэлүүдийг авч үзнэ.
  - 8.6.1. *Харилцаа холбооны технологийн эрсдэл*: Мэдээллийн дамжуулалтын нууцлал, аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийг харилцаа холбооны технологийн эрсдэл гэнэ. Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь



харилцаа холбооны холбогдох технологийг судлах, үнэлэх, хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох, турших замаар зохистой шийдвэр гаргана.

- 8.6.2. **Гэрээт төлөөлөгчтэй холбоотой эрсдэл:** Гэрээт төлөөлөгчийн эрсдэл гэж санаатай болон санамсаргүй байдлаар төлбөр саатуулах, хэрэглэгчийн эрхийг зөрчих, залилангийн болон луйврын гүйлгээ хийх зэрэг гэрээт төлөөлөгчийн үйл ажиллагаанаас шалтгаалах эрсдэл юм. Гэрээт төлөөлөгчийн алслагдмал байршил, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал, аюулгүй ажиллагааны зааврыг зөрчсөн ажиллагаа нь нэмэлт эрсдэлийг бий болгодог.
- 8.6.3. **Сэрэмжгүй байдлын эрсдэл.** Хэрэглэгчийн зүгээс аюулгүй ажиллагаа, цахим төхөөрөмжийн зохистой ашиглалтын талаарх мэдлэг дутуугийн улмаас бусад этгээдэд өөрийн хөрөнгийг ашиглуулах боломжийг бий болгох эрсдэл юм.
- 8.6.4. **Мэдээллийн системийн эрсдэл:** Хөдөлгөөнт банкны болон цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн төлбөрийн системийн хэвийн ажиллагаа алдагдах, нууцлал алдагдах, мэдээллийн сан устах зэрэг эрсдэл хамаарна.